



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Жинст сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/118/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
Bayankhongor@audit.gov.mn  
Баянхонгор хот  
2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70444470 Цахим хаяг:

Аудитор: Б.Бямбаа

Утас: 88050763 Цахим хаяг: Cpa\_baymbaa@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

Аудитын гэрчилгээ .....	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
Менежментийн захидал .....	9
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	9
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	11
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	12
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13

Аудитын гэрчилгээ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

ЖИНСТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ В.САНГИСҮРЭН ТАНАА

Аудитын гэрчилгээ № 1035

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Жинст сумын цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Жинст сумын цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Жинст сумын цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005010192

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## **Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Жинст сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цэцэрлэгийн эрхлэгч В.Сангисүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жинст сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жинст сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.25-наас 2020.02.27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Хонгорын үр сад аудит ХХК-ны аудитор Б.Бямбаа хариуцаж хэрэгжүүлэв.

Жинст сумын Цэцэрлэг 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.01.24-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Жинст сумын цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “ Хүүхэд нэг бүрийн авьяасыг дэмжин хөгжүүлэхэд багш ажилчид, эцэг эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Жинст сумын цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.  
Үүнд:

- Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган хамруулан сургах тойргийн хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх
- Бага насны хүүхдийг гэр бүлийн орчинд хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, малчдын хүүхдийн хөгжлийг эцэг эхийн оролцоон дээр түшиглэн хангах ажлыг зохион байгуулна.
- Багш бүр ээлжит хичээлийн бэлтгэлийг чанартай хийж, ЗАН болон багаараа хамтран нээлттэй, судалгаат, хамтын, зочинтой хичээлүүдийг явуулах
- Багш ажлын байран дээрээ мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх ажлыг хэвшүүлж, багшийн хөгжлийн төвийг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах
- Цогц аюулгүй орчин бүрдүүлж, гамшгийн эрсдэлийг бууруулах, даван туулах чадварын боловсролыг бусдад олгох гэсэн эрхэм зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Жинст сумын Цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Жинст сумын Цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох ХХК-ны Acolous программ хангамж ашигладаг байна.

Жинст сумын Цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Жинст сумын Цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 28 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "Их" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 154310,6 мянган төгрөгөөс тооцон 3086,2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 4721,8 мянган төгрөгөөр тооцов.

## **2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Жинст сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос -16754,7 мянган төгрөгөөр буюу 0,95%-иар хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл -9224,1 мянган төгрөгөөр тус тус буурсан, бараа материалын дансны үлдэгдэл 1678,1 мянган төгрөгөөр өссөн материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0,00	0,00	
Авлага	0	00	0
Урьдчилгаа	0,00	0,00	0,00
Бараа материал	24795,6	26473,7	1678,1
Үндсэн хөрөнгө	489263,8	480039,7	-9224,1
хуримтлагдсан элэгдэл	-43690,0	-52898,7	-9208,7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>470369,4</b>	<b>453614,7</b>	<b>-16754,7</b>
Өр төлбөр	0,00	0,00	0,00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	470369,4	453614,7	-16754,7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>470369,4</b>	<b>453614,7</b>	<b>-16754,7</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 1678,1 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалт, бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн өмнөх оноос -9224,1 мянган төгрөгөөр хасагдсан ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 7264,1 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсныг орлогод бүрэн тусгасан байна.

Жинст сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019.02.25-ны өдрийн 04 тоот тогтоолоор ашиглалтын шаардлага хангахгүй болсон 16488,3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх онд байхгүй, тайлант хугацаанд нэмж өр үүсээгүй, Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 470369,4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацаанд үр дүнгийн тайлангийн өөрчлөлттэй холбоотой байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 12 арга хэмжээнд зориулан 212590,7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 212590,7 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт 212590,7 мянган төгрөгийн зардлын 188269,7 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, Орон нутгийн төсвөөс 24321,0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 202180,2 мянган төгрөг буюу 95,1 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг 10410,4 мянган төгрөгөөр цалин, НДШ-ийн зардлыг хэмнэж буцаан төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 чиглэлээр 28 эрсдэлд нийт 28 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 4510,9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрэв.

Аудитаар дараах 4510,9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Хүүхдийн хоолны зардлын төсвийн хэмнэлтээр худалдан авалт хийж тайлант хугацааны эцэст 4154,4 мянган төгрөгийн хүнсний материал нөөцөлж үлдэгдлээр тайлагнасан байна.  
Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын 4-т “Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж зөрүүг тооцож байх” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.
2. Ламын гэгээний ойд зориулан ажилчдын цалингаас суутган авсан хандивыг 356,5 мянган төгрөгөөр илүү шилжүүлж зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

## 2.13. Шилэн дансны мэдээлэл

Жинст сумын цэцэрлэгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулсан байдал дараах байдалтай байна. Үүнд:

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	2	4
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	2	2	
4	Сар бүр	3	36	25	11	
5	Тухай бүр	8	96	69	27	
	Нийт	27	151	109	42	4

Улирал бүр мэдээлдэг төсвийн гүйцэтгэлийн мэдээний 3 дугаар улирлын мэдээ, тухай бүр мэдээлэх” Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт”-ийн 7 дугаар сарын мэдээ, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах заасан мэдэгдлийн 8 дугаар сарын мэдээ зэрэг 5 мэдээг санамсаргүй байдлаас хоцроосон байна. Мөн тухай бүр мэдээлэх таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа үйлчилгээний 1,5,7,9 дугаар мэдээг 10 сард нэмэлт зааварчилгаа өгсний улмаас дахин засварлаж өөрчлөлт оруулсны улмаас хоцроосон байна.

## 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Жинст сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Жинст сумын цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24,795,636.00	26,473,768.00
35	БАРАА МАТЕРИАЛ	24,795,636.00	26,473,768.00
351	Түүхий эд материал	20,826,768.00	20,826,768.00
35110	Тусгай зориулалттай материал	20,826,768.00	20,826,768.00
354	Хангамжийн материал	2,668,868.00	4,347,000.00
35410	Бичиг хэргийн материал	96,600.00	192,600.00
35460	Хүнсний материал	2,497,268.00	4,154,400.00
35600	Мал амьтад	1,300,000.00	1,300,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	445,573,838.78	427,141,018.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	445,573,838.78	427,141,018.72
392	Биет хөрөнгө	439,104,172.45	420,691,352.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	419,319,876.28	419,319,876.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,500,000.04	-22,202,384.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	21,088,370.00	21,520,595.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-11,245,941.32	-9,080,216.06
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,269,514.55	32,361,247.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,575,767.51	-21,227,766.21
393	Биет бус хөрөнгө	6,469,666.33	6,449,666.29
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-368,333.67	-388,333.71
39303	Бусад биет бус хөрөнгө	6,438,000.00	6,438,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	470,369,474.78	453,614,786.72
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	469,850,619.78	469,850,619.78
51	Засгийн газрын хувь оролцоо	469,850,619.78	469,850,619.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	111,802,083.00	111,802,083.00
51101	Өмч: - төрийн	111,802,083.00	111,802,083.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,072,973.89	3,072,973.89
51210	Өмнөх үеийн үр дүн	3,072,973.89	3,072,973.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	354,975,562.89	354,975,562.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	470,369,474.78	469,850,619.78

### 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

#### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

**Жинст сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	226,735,753.00	219,854,867.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,260,168.00	7,264,167.70
120	Нийтлэг татварын бус орлого	66,260,168.00	7,264,167.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	66,260,168.00	7,264,167.70
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	66,260,168.00	7,264,167.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	848,685.00	24,321,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	159,626,900.00	188,269,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	24,321,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	24,321,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	187,474,207.61	230,302,610.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	187,474,207.61	230,302,610.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	181,843,882.61	219,525,116.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	94,842,464.00	133,605,012.00
210101	Үндсэн цалин	93,571,512.00	129,114,517.00
210104	Урамшуулал	1,270,952.00	4,490,495.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,074,034.00	16,454,213.86
210201	Тэтгэврийн даатгал	11,074,034.00	16,454,213.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,125,512.00	20,426,376.00
210301	Гэрэл, цахилгаан	1,470,829.00	1,490,162.00
210302	Түлш, халаалт	19,522,183.00	18,786,214.00
210303	Цэвэр, бохир ус	132,500.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,016,670.00	6,660,210.00
210401	Бичиг хэрэг	270,470.00	1,070,810.00
210402	Тээвэр, шатахуун	555,000.00	789,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	918,800.00	611,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	195,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	227,400.00	3,994,100.00
2105	Нормативт зардал	21,914,532.00	18,640,408.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,000.00	31,200.00
210502	Хоол, хүнс	21,761,132.00	18,519,208.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	140,400.00	90,000.00
2107	Томилолт, зочны зардал	56,000.00	1,041,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	136,000.00
210702	Дотоод албан томилолт	56,000.00	905,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	671,200.00	730,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	671,200.00	480,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,048,470.61	21,967,897.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,071,290.00	380,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	178,000.00	1,679,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,799,180.61	19,908,897.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,630,325.00	10,777,493.14

**Жинст сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2132	Бусад урсгал шилжүүлэг	5,629,200.00	367,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	367,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	894,624.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	894,624.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	9,515,869.14
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	9,515,869.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	39,261,545.39	-10,447,742.43
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	5,788,090.63
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	5,788,090.63
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-5,788,090.63
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	39,261,545.39	-16,235,833.06

**4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	160,475,585.00	212,590,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	160,475,585.00	212,590,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	159,626,900.00	188,269,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	24,321,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	24,321,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	160,475,585.00	212,590,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	160,475,585.00	212,590,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	154,845,260.00	201,813,206.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	94,812,247.00	135,827,699.00
210101	Үндсэн цалин	85,922,583.00	119,235,593.00
210102	Нэмэгдэл	3,785,064.00	7,537,000.00
210104	Урамшуулал	5,104,600.00	9,055,106.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,585,396.00	14,705,381.86
210201	Тэтгэврийн даатгал	9,309,600.00	10,010,835.65
210202	Тэтгэмжийн даатгал	314,100.00	1,199,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	256,300.00	814,567.00
210204	Ажилгүйдлийн даатгал	64,100.00	153,407.21
210205	Эрүүл мэндийн даатгал	641,296.00	2,527,272.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,068,500.00	20,426,376.00
210301	Гэрэл, цахилгаан	861,653.00	1,490,162.00
210302	Түлш, халаалт	20,074,347.00	18,786,214.00
210303	Цэвэр, бохир ус	132,500.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,249,670.00	3,056,000.00
210401	Бичиг хэрэг	86,630.00	469,300.00

**Жинст сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210402	Тээвэр, шатахуун	740,000.00	789,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,079,840.00	926,000.00
210404	Ном, хэвлэл	45,000.00	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	375,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	298,200.00	446,400.00
2105	Нормативт зардал	20,153,950.00	20,507,540.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,000.00	31,200.00
210502	Хоол, хүнс	19,840,550.00	20,176,340.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,400.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,095,000.00	3,102,700.00
210604	Урсгал засвар	3,095,000.00	3,102,700.00
2107	Томилолт, зочны зардал	56,000.00	1,041,000.00
210702	Дотоод албан томилолт	56,000.00	1,041,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	344,000.00	850,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	344,000.00	650,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,480,497.00	2,296,510.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	123,000.00	2,296,510.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,630,325.00	10,777,493.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,629,200.00	367,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	367,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	894,624.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	894,624.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	9,515,869.14
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	9,515,869.14

**4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-4А

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
С01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	105,364,083.00	256,896,514.00	-31,355,269.20	00.00	330,905,327.80
С03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	105,364,083.00	256,896,514.00	-31,355,269.20	00.00	330,905,327.80
С07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-4,460,099.70	00.00	-4,460,099.70
С08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	111,802,083.00	354,975,562.89	3,072,973.89	00.00	469,850,619.78

**Жинст сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	111,802,083.00	354,975,562.89	3,072,973.89	00.00	469,850,619.78
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	111,802,083.00	354,975,562.89	3,072,973.89	00.00	469,850,619.78
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-16,235,833.06	00.00	-16,235,833.06
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	111,802,083.00	354,975,562.89	-13,162,859.17	00.00	453,614,786.72

**4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	00.00	00.00	212,590,700.00	202,180,206.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	00.00	212,590,700.00	202,180,206.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	00.00	212,223,700.00	201,813,206.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	00.00	142,843,900.00	135,827,699.00
210101	Үндсэн цалин	00.00	00.00	123,957,000.00	119,235,593.00
210102	Нэмэгдэл	00.00	00.00	9,688,000.00	7,537,000.00
210104	Урамшуулал	00.00	00.00	9,198,900.00	9,055,106.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	00.00	17,168,000.00	14,705,381.86
210201	Тэтгэврийн даатгал	00.00	00.00	11,917,100.00	10,010,835.65
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	1,240,900.00	1,199,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	992,700.00	814,567.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	248,200.00	153,407.21
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	2,769,100.00	2,527,272.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	00.00	21,321,000.00	20,426,376.00
210301	Гэрэл, цахилгаан	00.00	00.00	1,935,600.00	1,490,162.00
210302	Түлш, халаалт	00.00	00.00	19,235,400.00	18,786,214.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	00.00	150,000.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	00.00	3,061,100.00	3,056,000.00
210401	Бичиг хэрэг	00.00	00.00	460,300.00	469,300.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	00.00	790,000.00	789,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	00.00	955,900.00	926,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00	33,500.00	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00	375,000.00	375,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	00.00	446,400.00	446,400.00
2105	Нормативт зардал	00.00	00.00	20,515,600.00	20,507,540.00

**Жинст сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	00.00	31,200.00	31,200.00
210502	Хоол, хүнс	00.00	00.00	20,184,200.00	20,176,340.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00	300,200.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	00.00	3,102,700.00	3,102,700.00
210604	Урсгал засвар	00.00	00.00	3,102,700.00	3,102,700.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	00.00	1,062,500.00	1,041,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	00.00	1,062,500.00	1,041,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	00.00	851,800.00	850,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	00.00	651,800.00	650,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	200,000.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	2297100.00	2296510.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	00.00	00.00	2,297,100.00	2,296,510.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00	367000.00	367000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	00.00	367,000.00	367,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	367,000.00	367,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	00.00	00.00	212,590,700.00	202,180,206.86
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	00.00	00.00	188,269,700.00	178,753,830.86
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	00.00	188,269,700.00	178,753,830.86
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	00.00	00.00	24,321,000.00	23,426,376.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	24,321,000.00	23,426,376.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	00.00	00.00	14.00	14.00
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	08.00	08.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	05.00	05.00
63	Сурагчдын тоо дунджаар	108	98	87	83
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	00.00	00.00	07.00	07.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	00.00	00.00	04.00	04.00
650010	Гэрээт ажилтан	00.00	00.00	03.00	03.00

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

БЭЛТГЭСЭН: АУДИТОР  Б.БЯМБАА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ